



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/349

Мандалговь

Ойн зурвас хүлээн авах ажлын
хэсэг байгуулах тухай

Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын 2013 оны А-96/71 тоот тушаалын хавсралтаар баталсан "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам"-ын 3.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргын 2021 онд байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах гэрээнд тусгагдсан Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд Сайнцагаан суманд улсын чанартай авто зам дагуу 25 га талбайд хийгдсэн ойн зурвасын ажлын гүйцэтгэлийг шалган хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Н.Гантулга (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Гишүүд: П.Очирбат (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
Б.Цэрэнсугир (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)
О.Бархүү ("Дундговь-Ус" ОНӨҮГазрын захирал)
П.Уртнасан (Сум дундын ойн ангийн мэргэжилтэн)

Хоёр. Ойжуулалт, ойн зурваст тарьж ургуулсан тарьц, суулгацын амьдралтын хувь хэмжээг тогтоож, акт, танилцуулгыг 2021 оны 9 дүгээр сарын 25-ны дотор холбогдох газруудад хүргүүлэхийг ажлын хэсэг (Н.Гантулга)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ



481210391